| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,200,000.00 | 5,200,000.00 | - | 100% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 700,000.00 | 700,000.00 | - | 100% |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 290,640.00 | (9,360.00) | 97% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,906,400.00** | **9,183,800.00** | - | 100% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | 200,000.00 | - | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,706,400.00 | 8,983,800.00 | (722,600.00) | 93% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,972,600.00** | **8,672,600.00** | **(300,000.00)** | **97%** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,972,600.00 | 8,672,600.00 | (300,000.00) | 97% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,972,600.00 | 6,972,600.00 | - | 100% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,700,000.00 | (300,000.00) | 85% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **365,221,000.00** | **349,912,063.47** | **(15,308,936.53)** | **96%** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **362,161,000.00** | **346,998,563.47** | **(15,162,436.53)** | **96%** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 362,161,000.00 | 346,998,563.47 | (15,162,436.53) | 96% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **3,060,000.00** | **2,913,500.00** | **(146,500.00)** | **85%** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,060,000.00 | 2,605,500.00 | (454,500.00) | 85% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 308,000.00 | 308,000.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **500,000.00** | **(500,000.00)** |
| | **Урсгал зардлын дүн** | - | **500,000.00** | **(500,000.00)** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 500,000.00 | (500,000.00) |
| **2** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **500,000.00** | **(500,000.00)** |
| **31215** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **500,000.00** | **(500,000.00)** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 500,000.00 | (500,000.00) |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Нийслэл хотын хөгжлийн түүх, соёлын өвийг баримтжуулан хадгалж, хамгаалах, хойч үедээ уламжлуулах, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах, тэдний боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Улаанбаатар хотын музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгаа хийж, сан хөмрөгийг баяжуулна.
- Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын баталгаат орчин бүрдүүлж, үзмэрийг арчлан тордон, сэргээн засварлана.
- Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулж, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүлэгчийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно.
- Музейн судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна.
- Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна.
- Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ.
- Соёлын биет өвийг нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд холбогдох мэдээллийг дамжуулна.
- Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Дотоод хяналтыг байгууллага дээр хэрэгжүүлж байгаа орон тооны ажилтан байхгүй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал хөрөнгийн ашиглах

жил хугацаа элэгдлийг ямар аргаар хэрхэн байгуулах, Түүхийн дурсгалт соёлын өв хөрөнгийг яаж бүртгэх, номын фондын бүртгэл хэрхэн хийх, Үнэт цаас буюу үзвэрийн билетийг ямар дансанд бүртгэх зэрэг нь тодорхойгүй. Бодлогын бичиг баримтыг шинэчлэх шаардлагатай.

Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Дотоод хяналт шалгалтын удирдамжийн дагуу Улаанбаатар хотын музейн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой хяналт шалгалтыг явуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, нэгжгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын музейн 2022 оны санхүүгийн тайлан дахь мөнгөн гүйлгээнээс бусад ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар Музейн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,386.18 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 40,837.6 | 32,742.9 | (8,094.7) |
| Үндсэн хөрөнгө | 613,731.3 | 610,439.8 | (3,291.5) |
| **Нийт хөрөнгө** | **654,568.9** | **643,182.7** | **(11,386.2)** |
| Өр төлбөр | 2,600.0 | 98.2 | (2,501.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 651,968.9 | 643,084.5 | (8,884.4) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **654,568.9** | **643,182.7** | **(11,386.2)** |

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа даснууд оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,742.9 мянган төгрөг болж өмнөх оноос 8,094.7 мянган төгрөгөөр буурсан нь шаардлага хангахгүй болсон 6,697.2 мянган төгрөгийн үнэ бүхий хангамжийн материалыг акталж, 20,658.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан шинээр 19,261.1 мянган төгрөгийн бараа материал авсантай холбоотой гарсан өөрчлөлт байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 11,312.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 2,952.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/322 тоот тушаалын дагуу актлан данснаас хассан байна. Тайлант онд 11,651.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл нэмж байгуулсан байна.

Өмнөх онд байгууллагад өгөх өглөг 2,600.0 мянган төгрөг бүрэн төлөгдөж, тайлант онд 98,2 мянган төгрөгийн цалин өглөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант жилд үйл ажиллагааны үр дүнгээр 5,932.3 мянган төгрөгийн, үйл ажиллагааны бус буюу үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзад 2,952.0 төгрөгийг бүртгэснээр нийт 8,884.4 мянган төгрөгийн алдагдалтай гарсан.

Улаанбаатар хотын музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 10,736.4 мянган төгрөгөөр буюу 2,8 хувиар буурсан байна.

Өмнөх онд 595,5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн бол 2022 онд 2,605.5 мянган төгрөг төвлөрч орлого өмнөх оноос 2,010.0 мянган төгрөгөөр илүү төвлөрсөн ба төлөвлөсөн хэмжээнээс 454,5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 568,731.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,060.0 мянган төгрөг, нийт зарлагыг 571,791.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч нь төсвийг хянан үзээд төсвийн төслийг 206,570.1 мянган төгрөгөөр бууруулан 365,221.0 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлагийн хөтөлбөрийн нийт 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 365,221.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 362,161.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 3,060.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 346,998.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,913.5 мянган төгрөг, нийт 349,912.1 мянган төгрөгийн орлого, санхүүжилт орсон байна.

Тайлант онд 362,161.0 мянган төгрөгийн санхүүжилт төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 346,998.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 15,162,4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

2022 оны батлагдсан төсвөөс цалин хөлс, болон нэмэгдэл, урамшуулал, унаа хоолны зардал 878.9 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэл 943.7 мянган төгрөгөөр, бусад урсгал зардлууд 12,686.3 мянган төгрөгөөр, нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 300.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан дүнтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Үндсэн үйл ажиллагаа | 330,534.70 | 325,977.88 | 4,556.8 | 98,6% |
| | Эрдэм шинжилгээний зардал | 8,613.70 | 7,336.95 | 1,276.7 | 85,2% |
| | Бусад урсгал шилжүүлэг | 8,972.6 | 8,672.6 | 300.0 | 96,7% |
| | Үзмэр худалдаж авах зардал | 12,000.00 | 3,250.0 | 8,750.0 | 27,1% |
| | Түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт | 5,100.00 | 4,674.63 | 425.3 | 91,7% |
| | **Нийт дүн** | **365,221.00** | **349,912.06** | **15,308.80** | |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт төсвийн санхүүжилтийн дансанд 500.0 мянган төгрөгийн орлого орж, Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| | Эрдэм шинжилгээний зардал | 2022.01.01-2022.12.31 | 1 боть ном, 2 өгүүллэг | "Улаанбаатарын мэдээ сонин" цуврал эмхэтгэл номын эхний боть болгон хэвлүүлсэн.Уг сонины эмхэтгэлийг хэвлүүлэхэд 3,200,000 төгрөг зарцуулсан. Үлдсэн төсвийг Нийслэл хүрээ зурагт ном хэвлүүлэх болон бусад судалгааны зардалд зарцуулсан.<br>Биелэлтийн хувь: 100%<br>2022 онд судалгааны өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлэхэд 4,100,000 төгрөг зарцуулахаар төсөвлөсөн ч судалгааны бүх өгүүлэл, нийтлэлийг үнэ төлбөргүй хэвлүүлсэн.<br>Биелэлтийн хувь: 100 | 8,613.70 | 7,336.95 |
| | Үзмэр худалдаж авах зардал | 2022.01.01-2022.12.31 | 5 үзмэр | Музейн сан хөмрөгийг түүхэн хөгжлийн явцад бий болсон эд өлгийн зүйлээр баяжуулах ажлын хүрээнд иргэн Т.Туул, Л.Тайван нартай "Музейд эд өлгийн зүйл худалдан авах гэрээ" байгуулан, "Музейд эд өлгийн зүйл хүлээж авсан акт" үйлдэн 7 дэсийн 11 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг музейн захирлын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар 3,250,000.00 төгрөгөөр худалдан авсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үлдэгдэл 8,750,000.00 төгрөгийг хэмнэв.<br>Биелэлтийн хувь: 100% | 12,000.00 | 3,250.0 |
| | Түүх, соёлын дурсгалт | 2022.01.01-2022.12.31 | 80ш | Тайлант хугацаанд сан хөмрөгийн үзмэрийн | 5,100.00 | 4,674.63 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зүйлсийн хадгалалт хамгаалалт | | | хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулахын тулд нийт 4,674,630 төгрөгийг зарцуулсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үлдэгдэл 425,370.00 төгрөгийг хэмнэв.<br><br>Биелэлтийн хувь: 100% | | |
| | Бусад урсгал шилжүүлэг | 2022.01.01-2022.12.31 | | Өндөр насны тэтгэвэрт 1 хүн гарсан. Тэтгэмжийн зардалд 6,972,600 төгрөг зарцуулсан. Буцалтгүй тусламж нийт 1,100,000 төгрөг, бусад тэтгэмжийн зардалд 600,000 төгрөг тус тус зарцуулсан. Үлдэгдэл 300,000 төгрөгийг хэмнэсэн. | 8,972.6 | 8,672.6 |
| | Үндсэн үйл ажиллагаа | 2022.01.01-2022.12.31 | | | 330,534.70 | 325,977.88 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улаанбаатар хотын музейн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гроут финанс Аудит ХХК-ийн захирал Б.Бямба, туслах аудитор Т.Гантуул, чанарын хяналтыг аудитор Ч.Хүнбиш нар гүйцэтгэж, НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын музейн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гроут финанс Аудит ХХК-д  2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 1% гэж үнэлэн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшинг 75 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 371,495.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,714.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,787.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор  байгууллага 2022 оны 7 дугаар сард Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст  Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөг хүргүүлсэн.

Төлөвлөгөөг гүйцэтгэлээр зарцуулсан зарцуулалтын тайлантай харьцуулж биелэлтийг дүгнэн доор оруулаа. Үүнд:

-Байгууллагын тогтмол зардлыг 30 хувиар хэмнэхээр төлөвлөснөөс биелэлт 12 хувь

-Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал 10 хувиар хэмнэхээр төлөвлөснөөс биелэлт 4 хувь хэмнэсэн.

-Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 100 хувь хэмнэсэн

-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 15 хувиар хэмнэхээр төлөвлөсөн бол 40 хувиар хэмнэсэн. Үүнд багтах хэмнэсэн зардал нь эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх зардал бөгөөд тайлант онд 3 судалгааны нийтлэл бэлтгэн хэвлүүлсэн бөгөөд судалгааны өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлэхэд 2,100.0 мянган төгрөг зарцуулахаар төсөвлөсөн ч судалгааны бүх өгүүлэл, нийтлэлүүдийг үнэ төлбөргүй хэвлүүлсэн.

-Бараа, үйлчилгээний бусад зардлыг 20 хувиар хэмнэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7 хувь хэмнэсэн. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, үүнтэй холбоотой зардал гараагүй байна.

-Бусад урсгал шилжүүлэг 10 хувиар хэмнэхээр төлөвлөснөөс 15 хувиар тус тус хэмнэсэн байна.

Хэмнэсэн зардлын нийт батлагдсан төсөвт эзлэх хувь 4.2 % ба нийт 15.308.9 мянган төгрөг хэмнэсэн байна. Орлогын төлөвлөгөө 3,060.0 мянган төгрөг гүйцэтгэл 2,913.5 мянган төгрөг 95.2 хувь буюу 146.5 мянган төгрөгөөр орлого дутуу төвлөрүүлсэн. 2022 оны жилийн эцэст 15,162.4 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Мөн тайлант жилд хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, өр төлбөрөө бүрэн барагдуулан ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2022 онд нийт 372,372.1 мянган төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 372,372.1 мянган төгрөгийн 32 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж бараа материалын дансны ангилал түүний бүртгэл, цалинг холбогдох ажилтанд дутуу тооцож

олгосон ажил гүйлгээг залруулж өглөгөөр бүртгэх зөвлөмж, унаа хоолны мөнгийг төсөвлөсөн дүнгээс хэтрүүлж олгосон зэрэг нийт 3 асуудалд зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүйгээс 191,193.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгсний дагуу тайлант жилд Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн капиталжуулсан хөрөнгийн нэрийг буруу бүртгэсэн асуудалд 1 зөвлөмж өгснийг нэрийг залруулан зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт*, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 190,333.0 | 1 | 190,333.0 | 100% |
| Зөвлөмж | 1 | 860.0 | 1 | 860.0 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **191.193.0** | **2** | **191.193.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийг зөв ангилан бүртгэх, элэгдлийн тооцооллыг хөрөнгө нэг бүрээр нь тооцооллыг шалгаж байх. Түүхэн дурсгалт барилга байгууламж нь жил ирэх тусам үнэ цэнэ өсөх ёстой учир уг хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлж, бүртгэлд тусгах талаар арга хэмжээг холбогдох дээд шатны байгууллагуудад асуудал дэвшүүлж ажиллах нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,652.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс, 3,202.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,450.0 мянган төгрөгийн зөрчил дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Байгууллагын даргын буруу шийдвэр гаргасны улмаас Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн гаргасан шийдвэрийг үндэслэн нэхэмжлэл гаргагчийн ажиллаагүй байх хугацааны 3,202.8 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөж олгосоныг цаашид удирдлагын шийдвэрийг хуулийн дагуу гаргах талаар албан шаардлага хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу цахим баримтгүй ажил гүйлгээ гарсантай холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт:* Мөнгөн хөрөнгийн зарлагын баримтнаас түүвэрлэлт хийн анхан шатны баримттай тулган шалгах явцад нийт 1,450.0 сая төгрөгийн 2 гүйлгээ цахим баримтгүй зөрчил илэрсэн.

*1.2 Өгсөн зөвлөмж*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*". Мөн "*Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлтэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааварын 6.5-т Төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох цаасан болон цахим баримт юм*" гэж тус тус заасны дагуу анхан шатны баримтад зайлшгүй хавсарган бүртгэх.

2. **Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал**

*2.1 Илрүүлэлт:* 2022 онд үндсэн хөрөнгийн ангилал дахь түүх соёлын дурсгалт өв данснаас тавилга эд хогшил дансанд шилжүүлж бүртгэхдээ хөрөнгийн ашиглалт хэвийн байхад уг хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 100 хувиар тооцож тайлант үеийн элэгдлийн зардлыг нэмэгдүүлсэн.

*2.2 Өгсөн зөвлөмж*

Данс хооронд шилжсэн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан ч цаашид ашиглах боломжтой бол УСНББОУС 17-н 67. -т зааснаар *Хөрөнгийн үлдэх өртөг*

*ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцоололоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцоололын өөрчлөлт ба Алдааны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцоололын өөрчлөлт байдлаар тайлагнана*. Мөн тус стандартад зааснаар *Хөрөнгийн удирдлагын бодлого нь хөрөнгийн элэгдэл хуучралтыг нэмэгдүүлдэг тохиолдолд түүний ашиглалтын хугацааг дахин хянан үнэлж, зохих ёсоор залруулах хэрэгтэй*.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим баримтгүй гарсан гүйлгээ | 1 | 1,450.0 | | | | | 1 | 1,450.0 | | | | |
| Данснаас дансны хооронд шилжүүлж бүртгэсэн хөрөнгийн элэгдэлийг 100 хувь элэгдүүлж данснаас хассан | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Шүүхийн шийдвэрийг үндэслэн гаргасан үр ашиггүй зардал | 1 | 3,202.9 | | | 1 | 3,202.9 | | | | | | |
| **Дүн** | **3** | **4,652.8** | | | **1** | **3,202.9** | **1** | **-** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

ГРОУТ ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР Ч. ХҮНБИШ

**ХЯНАСАН:**

ГРОУТ ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Б.БЯМБА

*Аудитын код: ХАК-2023/799/ НА-СА-ТШЗ*